


2022

Монгол Улсын эхний хагас жилийн эдийн засаг, төсвийн ТОЙМ





МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA



Монгол Улсын Сангийн яамны санаачилгаар, Европын холбооны буцалтгүй тусламжаар Дэлхийн банкны хэрэгжүүлж буй Монгол Улсад засаглалын бэхжүүлэх төслийн хүрээнд энэхүү танилцуулгыг бэлтгэн гаргав.

Эдийн засаг

Засгийн газар өнгөрсөн 2 жилд цар тахлын нөхцөл байдлаас үүдсэн эдийн засгийн уналтыг сааруулж, эдийн засгийг сэргээх мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж ирсэн бол дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, урт хугацааны зорилтыг хангах **“Шинэ сэргэлт”-ийн бодлогыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.**



ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

/2022 оны эхний хагас жил/

ОНЫ
ҮНЭЭР **23.0** ИХНАЯД
ТӨГРӨГ **16%**

2015 оны
зэрэгцүүлэх
үнээр **12.8** ИХНАЯД
ТӨГРӨГ **1.9%**



Хөдөө, аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг өмнөх оны мөн үеэс **11.3 хувиар**, Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг **4.9 хувиар өссөн бол**, уул уурхайн олборлолтын нэмэгдэл өртөг **28.8 хувиар**, аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг **1.2 хувиар буурсан байна. Үүний үр дүнд** эдийн засгийн өсөлт өмнөх оны хагас жилтэй харьцуулахад **1.9 хувиар өссөн байна.**


ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН ОРОЛЦООГООР:

- Хөдөө аж ахуй 1.8%
- Аж үйлдвэр, барилга -0.1%
- Уул уурхай, олборлолт **-3.7%**
- Үйлчилгээ 2.2%
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 1.7%

Уул уурхайн олборлолтын салбарын нэмэгдэл өртөг буурахад нүүрс олборлолт **42.8 хувь**, газрын тос олборлолт **95.0 хувь** тус тус буурсан нь нөлөөлж байна.

Эх үүсвэр: www.1212.mn

ИНФЛЯЦ



2022 оны эхний хагас жилд Инфляц **16.1** нэгж хувь гарсны **57.1** хувь буюу **9.2** нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.



Нийт **373** нэр төрлийн бараа, үйлчилгээний **200** нь импортын бараа байгаа бөгөөд энэ нь нийт жингийн **45.5** хувийг эзэлж байна.



Эх үүсвэр: www.1212.mn

ГАДААД ХУДАЛДАА

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ



Төлбөрийн тэнцэл 2021 оны эхний хагас жилд - **54.2 сая америк долларын** алдагдалтай байсан бол 2022 оны эхний хагас жилд алдагдал өмнөх оны мөн үеэс **1.0 тэрбум америк доллароор** өсч, **1.1 тэрбум америк долларын** алдагдалтай болсон байна.

Эх үүсвэр: www.1212.mn, www.mongolbank.mn

2022


Нэгдсэн төсвийн хагас жилийн тойм

Тодотгол

2022 онд Монгол Улсын Засгийн газар 2 удаа төсвийн тодотгол хийгээд байна. 2022 оны **1-р сарын 31-ний өдөр ахмад настны тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх** боломжийг бий болгосон бол **4-р сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг батлан** төсвийн 2 дахь удаагийн тодотголыг тус тус хийсэн байна.



ТӨСВИЙН ТЭНВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ



АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ

Харилцах болон хадгаламжийн дансны өөрчлөлт	0.7	ИХНАЯД ТӨГРӨГ
Засгийн газрын бонд	-0.1	ИХНАЯД ТӨГРӨГ
Засгийн газрын зээл	0.3	ИХНАЯД ТӨГРӨГ
Өмч хувьчлал	0.001	ИХНАЯД ТӨГРӨГ

2022 оны хагас жилийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ **7.3 их наяд төгрөг** болж, өмнөх оны мөн үеэс **919.2 (14.3%) тэрбум төгрөгөөр**, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2022 оны эхний хагас жилд **8.2 их наяд төгрөг** болж, **тэнцвэржүүлсэн тэнцэл 844.0 тэрбум төгрөгийн** алдагдалтай гарчээ

ТӨСВИЙН ОРЛОГО

НИЙТ ОРЛОГО **8.0** ИХНАЯД ТӨГРӨГ

0.6 ИХНАЯД ТӨГРӨГ
Тогтворжуулалтын сан
ТАТВАРЫН ОРЛОГО 6.9 ИХНАЯД ТӨГРӨГ

1.5 ИХНАЯД ТӨГРӨГ
Орлогын албан татвар

1.3 ИХНАЯД ТӨГРӨГ
НД-н орлого

0.1 ИХНАЯД ТӨГРӨГ
Хөрөнгийн албан татвар

1.8 ИХНАЯД ТӨГРӨГ
НӨАТ

0.5 ИХНАЯД ТӨГРӨГ
Онцгой албан татвар

0.009 ИХНАЯД ТӨГРӨГ
Тусгай зориулалтын орлого

0.6 ИХНАЯД ТӨГРӨГ
Гадаад үйл ажиллагааны орлого

1.0 ИХНАЯД ТӨГРӨГ
Бусад татвар, төлбөр, хураамж

ТАТВАРЫН БУС ОРЛОГО 0.4 ИХНАЯД ТӨГРӨГ

0.3 ИХНАЯД ТӨГРӨГ
Нийтлэг татварын бус орлого

0.002 ИХНАЯД ТӨГРӨГ
Хөрөнгийн орлого

0.74 ИХНАЯД ТӨГРӨГ
Тусламжийн орлого


Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2022 оны эхний 6 сарын байдлаар **8.0 их наяд төгрөг**т хүрч, төлөвлөсөн хэмжээнээс **71.8 тэрбум төгрөгөөр** дутуу биелэлттэй байна.

Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **895.4 тэрбум төгрөг** буюу **13 хувиар** өссөн үзүүлэлт юм.



ТӨСВИЙН ЗАРЛАГА

НИЙТ ЗАРЛАГА **8.2** ИХНАЯД
ТӨГРӨГ



1.2 ИХНАЯД
ТӨГРӨГ
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ

0.03 ИХНАЯД
ТӨГРӨГ
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ
ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ

7.0 ИХНАЯД
ТӨГРӨГ
УРСГАЛ ЗАРДАЛ


Урсгал шилжүүлгийн зардал мөн оны өмнөх үеэс дараах өөрчлөлттэй байна.

- Урсгал шилжүүлгийн зардал **800.9 (20.6%) тэрбум төгрөг** ▲
- Бараа үйлчилгээний зардал **416.4 (20.2%) тэрбум төгрөг** ▼
- Хүүгийн зардал **4.6 (1.1%) тэрбум төгрөг** ▼

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2022 оны эхний хагас жилд **8.2 их наяд төгрөг** болж, өмнөх оны мөн үеэс **693.7 (9.3%) тэрбум төгрөгөөр** өссөн байна.


Хөрөнгийн зардал **1.2 их наяд төгрөг** болж, өмнөх оны мөн үеэс **299.3 (34.8%) тэрбум төгрөгөөр** өссөн байна. Зардлын эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлттэй байна.

- Байгууламжийн **21.6%** ▲
- Их засварын зардлынх **0.3%** ▲
- бусад хөрөнгийн зардлынх **15.3%** ▼
- тоног төхөөрөмжийн зардлынх **5.7%** ▼
- стратегийн нөөц хөрөнгийн зардлынх **0.9%** ▼



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨР



ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ӨР

ЗАСГИЙН ГАЗРЫН БУСАД ӨР

ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР

28,502.4 ТЭРБУМ
ТӨГРӨГ

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ

51.1%



Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ)-ийн ДНБ-д эзлэх харьцаа 2022 оны хагас жилийн байдлаар 51.1 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь хуулийн хязгаар болох 70 хувийг хангахаар байна.






2022

Макро эдийн засаг болон төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл



Төсвийн зарлага

Хэмнэлтийн горимыг байнгын шинжтэй мөрдөж хэрэгжүүлснээр төрийн бүх шатанд үрэлгэн байдал арилж, төсвийн зарцуулалтын үр ашиг сайжрах, төсвийн зарлагын өсөлт дунд болон урт хугацаанд буурах ач холбогдолтой байх болно.



2022 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

2022
ХБГ*

*-Хүлээгдэж буй гүйцэтгэл


Дотоодын нийт бүтээгдэхүүн	47.6 их наяд төг	
Эдийн засгийн өсөлт	2.6%	
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого	15.5 их наяд төг	
Нэгдсэн төсвийн нийт зарлага	17.9 их наяд төг	
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-2.3 их наяд төг	
ДНБ-д эзлэх хувь	-5.1 %	
ЗГ-н өрийн нийт хэмжээ	28.2 ихнаяд төг	
ДНБ-д эзлэх хувь	60.7 %	

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгаа тэлж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор **“Шинэ сэргэлтийн бодлого”**-ыг үргэлжлүүлэн, боомтын шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж байна. Үүнд:


1. Боомтын сэргэлтийн бодлого
2. Эрчим хүчний сэргэлтийн бодлого
3. Аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлого
4. Хот хөдөөгийн сэргэлтийн бодлого
5. Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого
6. Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлого




$$a^2 + b^2 = (a+b)^2 - 2ab$$



Search





МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ



Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж,
Засгийн газар II байр Д корпус, Улаанбаатар хот 15160,



Монгол Улс
267350



tusuv@mof.gov.mn



www.mof.gov.mn
www.iltod.mof.gov.mn

ХОЛБОО БАРИХ